



# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

## ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

### ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2023 оны 10 дугаар сарын 18-ны өдөр, Баасан гараг*

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-3</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>4-9</i>
<hr/>	
<i>1.Тусгай хяналтын дэд хорооны даргыг сонгох тухай</i>	<i>4-9</i>

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы  
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 10 дугаар  
сарын 18-ны өдөр /Баасан гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 9 цаг 35 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Дэлгэрсайхан, Г.Хосбаяр, Р.Эрдэнэбүрэн;  
Чөлөөтэй: Э.Бат-Амгалан, Э.Болормаа, Д.Ганбат, Н.Номтойбаяр, Ж.Энхбаяр, Л.Энхнасан.

**Нэг.Тусгай хяналтын дэд хорооны даргыг сонгох тухай**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаярыг Тусгай хяналтын дэд хорооны даргад нэр дэвшүүлж байгаа талаар танилцуулав.

Танилцуулга болон нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар, С.Эрдэнэболд тавьсан асуултад Тусгай хяналтын дэд хорооны даргад нэр дэвшигч, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин үг хэлэв.

**Г.Тэмүүлэн:** Тусгай хяналтын дэд хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаярыг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16  
Татгалзсан: 0  
Бүгд: 16  
100 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн “Дэд хорооны даргыг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолыг уншиж танилцуулав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 21 минут үргэлжилж, 25 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 64.0 хувийн ирцтэйгээр 09 цаг 56 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**  
2024 оны 10 дугаар сарын 18-ны өдөр,  
Баасан гараг Төрийн ордон “Их эзэн  
Чингис хаан” танхим 09 цаг 35 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Г.Тэмүүлэн:** Байнгын хорооны гишүүддээ энэ өглөөний мэндийг хүргэе ээ. Байнгын хорооны ирц бүрдсэн байна. Та бүхэнд ирцийн мэдээг танилцуулъя. Очирбатын Амгаланбаатар гишүүн, Чинбаатарын Анар, Батын Батбаатар, Нацагдоржийн Батсүмбэрэл Хажсекбэрийн Жангабыл, Нанзадын Наранбаатар, Пүрэвсүрэнгийн Наранбаяр, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Өлзийхүүгийн Шижир, Дамдины Цогтбаатар, Сүхбаатарын Эрдэнэболд, Баттөмөрийн Энхбаяр гишүүд хүрэлцэн ирсэн байна аа. Сайнзориг гишүүн ирсэн байна. Ингээд 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал нэг байгаа. Дэд хорооны даргыг сонгох тухай асуудал байна. Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу? Алга байна. Ингээд хэлэлцэх асуудалдаа орцгооё.

Дэд хорооны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцэж эхэлье.

Дэд хорооны даргад нэр дэвшүүлэх гишүүнийг би та бүхэнд танилцуулъя. МАН-ын бүлгээс Тусгай хяналтын дэд хорооны даргаар Баттөмөрийн Энхбаяр гишүүнийг нэр дэвшүүлж байгаа. Та бүхэнд товч анкетыг нь танилцуулъя. Төгссөн сургууль Чойбалсан хотын ерөнхий боловсролын I дүгээр дунд сургууль, Монгол улсын Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр мөн 1999 онд Монгол Улсын Хууль зүйн сургуулийг магистр мэргэжлээр төгссөн.

Ажилласан байдал нь Улаанбаатар эрдэм дээд сургуулийн багшаар, мөн Улсын Их Хурлын гишүүний туслах болон Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн ажлын албанд референт хуулийн зөвлөхөөр ажиллаж байсан. 2003-аас 2006 онд Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын Тамгын газрын даргаар, 2006-аас 2007 онд ХЗДХЯ-ны Төрийн захиргаа, удирдлагын газрын даргаар, 2009-өөс 2011 онд НДЕГ-ын тамгын дарга, 2011-ээс 2013 онд МАН-ын даргын зөвлөхөөр 2014-2016 онд МАН-ын бүлгийн зөвлөхөөр, 2016-аас 2018 онд ХЗДХ-ийн дэд сайдаар, 2020-оос 2024 онд Улсын Их Хурлын гишүүнээр, 2023 онд Улсын Их Хурлын ХЗБХ-ны даргаар, мөн 2023 оноос Монгол Улсын Засгийн газар гишүүн, ХЗДХ-ийн сайдаар ажиллаж байсан болно.

Ингээд Тусгай хяналтын дэд хорооны дэд даргаар Баттөмөрийн Энхбаяр гишүүнийг нэр дэвшүүлж байна. Дэд хорооны даргад нэр дэвшүүлэх асуудлаар саналтай гишүүд байна уу? Асуулт байна уу? Байж болно Эрдэнэболд гишүүнээр тасаллаа. Батбаатар гишүүн асуулт асууя.

**Б.Батбаатар:** Улсын Их Хурал дээр ингээд Байнгын хороо, за Байнгын хороо ч яах вэ. Тэгээд дэд хороо ялангуяа энэ хяналт шалгалтын чиг үүрэг бүхий дэд хороо, хүний эрхийн ч байдаг юм уу Төсвийн зарлагын хяналтын хороо ч байдаг юм уу. Ингээд энэ Дэд хороон дарга эд нар энэ талдаа эрх баригч юм уу засагт хамтарсан бүлгүүдийг санал оруулаад, бүрэлдэхүүнийг нь, даргыг нь бүлгээс оруулаад байх нь дэд хороон дарга болж байгаа энэ ч ойлгомжтой. Дэд хороон дарга болж байгаагийн хувьд юу гэж боддог юм бэ? Нөгөө хууль зүйн талын ажил хийж байсан хүн учраас хууль эрх зүйн талаасаа нэгд нь, 2-т нь ер нь парламент чинь өөрөө иргэдийн төлөөлөл гэж явж байгаа шүү дээ Засгийн газрын төлөөлөл бол биш. Парламентын олонх нь засгийн газраа бүрдүүлдэг. Энэ тал дээр

юу гэж бодож байгаа юм бэ гэдэг ийм 2 л юм асууя.

**Г.Тэмүүлэн:** Энхбаяр гишүүн. Цогтбаатар гишүүн.

**Д.Цогтбаатар:** Үгүй ээ энэ саяын асуулт бол зүй ёсны асуух асуулт. Гэхдээ энэ бол яг одоо энэ нэр дэвшиж байгаа хүнтэйгээ огт хамаагүй асуулт байгаа. Энийг бол улс төрийн байр суурийн асуудал бүлэг юм уу тэр холбогдох институц нь хариулах ёстой байх аа.

**Г.Тэмүүлэн:** Эрдэнэболд гишүүн асуулт асууя.

**С.Эрдэнэболд:** Баярлалаа. Энхбаяр гишүүн ээ асуулт асуух гэсэн юм. Тусгай хяналтын дэд хороо гэхээр ер нь бол нууцтай холбоотой. Дээрээс нь одоо энэ хуулийг хэрэгжүүлж байгаа байгууллагуудын үйл үйл ажиллагаа, тэд нарын төсөв, орон тоо ч гэдэг юм уу ингээд нууцын зэрэгтэй материалтай юу чинь нэлээн холбоотой байгаа шүү дээ нэг талаасаа, нөгөө талаасаа болохлоороо та бол олон удаа бас яриад байдаг, яг энэ одоо хуулийг хэрэгжүүлэх салбарт хүний эрхийн зөрчил их байна аа. Тэгээд дээрээс нь нөгөө нэг эрүүдэн шүүх гээд холбоотой зүйлүүд маш олон кэйсүүдийг бид нар ярьдаг шүү дээ. Тэгэхээр ер нь бол ХЗБХ-н дээр ч гэсэн энэ Хүний эрхийн Комисс дээр очиж байхад бас ингээд л ярианууд гарсан. 8 сарын дундуур бас нэг амь насаа алдсан хүмүүжигч шалгагдаж байсан хүнтэй холбоотой асуудал ингээд л гараад л явдаг. Тийм нэг хүмүүсийн дунд маш их тийм эргэлзээ тээнэгэлзэл байдаг. Ер нь бол тусгай байгууллагуудын хүний эрхийг хангах үйл ажиллагаагаа явуулахдаа хүний эрхийг хангах чиглэл дээр маш олон ийм нийгэмд скандалууд гараад байдаг шүү дээ. Тэгэхээр яг энэ чиглэл дээр бол ажиглаад байхад сая бол энэ Хууль зүйн яам тэгээд энэ төсөвтэй холбоотой тодотголыг ингээд ажиглаж байхад бол ихэнх төсвүүд бол ерөөсөө нөгөө нэг барилга байгууламж дэд бүтэц рүү чиглэсэн ийм төсвүүд яваад байдаг.

Яг нөгөө нэг хүний эрхийг хамгаалах чиглэлтэй тэр үйл ажиллагаа руу чиглэсэн төсвүүд бол маш бага байдаг юм байна лээ.

Тэгэхээр ер нь бол та байнгын мэдээж ганцаараа нэр дэвшиж байгаа сонгогдоод ажиллах нь тодорхой. Энэ дээрээ бол болж өгвөл тэр яг энэ Тусгай хяналтын дэд хорооны чиглэлээр энэ чиглэлийн байгууллагуудын үйл ажиллагаанд хүний эрхийг хангах чиглэл дээр мэдээж би ингэж ажиллана тэгж ажиллана гээд ил тод ярих нь бол юу учир боломжгүй байж магадгүй. Яагаад гэхээр энэ чинь нэг тодорхой хэмжээгээр гүйцэтгэх ажиллагаа ч гэдэг юм уу олон төр төрлийн зүйл байгаа шүү дээ. Гэхдээ энэ чиглэл дээр ер нь хүний эрхийг хангах нь маш чухал байгаа. Хүний эрхийг хангаж ажиллах тал дээр бол бид нар бүр онцгой анхаарахгүй бол нөхцөл байдал ерөөсөө сайжрахгүй байгаад байна л гэсэн ойлголттой байгаад байдаг. Статистикийн мэдээллийг харж байхад ч иргэд олон нийтийн гомдлыг харж байхад ч тэр. Тэгээд энэ дээрээ та ямар зарчим баримталж ажиллах вэ? Яагаад энийг асууж байгаа юм бэ гэхээр дээр нөгөө ХЗБХ-ны хурал дээр бас яригдсан нэг зүйл нь болохоор Европын Холбоо ч гэдэг юм уу ингээд хүний эрхийг дээдэлсэн улсуудад ялангуяа энэ чиглэлийн олон нийтийг гэгээрүүлэх энэ чиглэлийн энэ байгууллагуудын сургалтын ажиллагаа бол маш тогтмол төсөв сайтай явагдаад байдаг. Манай дээр болохоороо миний ойлгож байгаагаар ХЗДХЯ-ан дээр 4 ажлын байр гарсан гэж байгаа. Тэгээд тэр 4 хүн ч гэсэн ийм том генерац ажлыг хийж чадахгүй байхгүй юу. Тэгэхээр энэ дээр бол бид нар маш олон тийм өргөн хүрээтэй ажиллагаанууд хэрэгтэй байгаад байгаа юм. Ялангуяа энэ бодлогын чиглэлээр зарчмын чиглэл дээр байгаа. Энэ дээр та энэ Дэд хорооны даргаар сонгогдоод ажиллах хугацаандаа ямар зарчим баримтлах юм бэ гэдэг асуулт байгаа юм.

**Г.Тэмүүлэн:** Эрдэнэболд гишүүнд баярлалаа. Энхбаяр гишүүн хариулах уу? Энхбаяр гишүүнд микрофон өгье.

**Б.Энхбаяр:** Тэгэхээр Тусгай хяналтын дэд хорооны үндсэн чиг үүрэг бол Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг бататган бэхжүүлэхтэй холбоотой нөлөөллийн гүйцэтгэлийн шалтгаанаар төсөв санхүүгийн асуудлыг хэлэлцэх шийдвэрлэх ийм үндсэн чиг үүрэг байдаг. ер нь гүйцэтгэх ажил хийх эрх бүхий субъектүүдийн гол онцлог бол Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний үндсэн эрх, эрх чөлөө рүү хуульд заасан арга хуульд заасан хүрээнд нэвтрэх ийм онцгой бүрэн эрхтэй байдаг. Тэгэхээр хүний үндсэн эрх эрх чөлөөнд тэр хуульд заасан үндэслэл журмаас гадуур халдаж байна уу, үгүй юу гэдгийг хяналт тавих асуудал бол энэ Дэд хорооны онцгой чиглэл байх болно. Өөрөөр хэлбэл хүний үндсэн эрх зөрчигдөхөөс хамгаалах, сэргийлэх, хяналт тавих асуудал байгаа. Миний ойлгож байгаагаар бол энэ парламент ер нь Тусгай албад субъектүүдээ хуулийн хүрээнд ажиллаж байна уу, үгүй юу гэдгийг хянах асуудал бол энэ ард түмний нэг талаасаа, нөгөө талаасаа үндэсний аюулгүй байдлын, 3 дугаарт бол ер нь бусад их тийм үр дагавартай байдаг. Ер нь хамгийн анх парламент ер нь хянадаг байх уу, үгүй юу гэдэг асуудал бол дэлхийн 2 дугаар дайнаас улбаатай.

Дэлхийн 2 дугаар дайны гарах нэг үндсэн шалтгааны нэг нь Герман улсын тухайн үеийн нууц цагдаагийн байгууллага, хил хязгаараас давсан хүний эрхэд халдсан, улмаар тухайн Герман улсыг магадгүй дайн руу түлхэж оруулахад их нөлөөлсөн гэж үздэг, нөлөөлсөн. Энэний хохирлыг тухайн улс дэлхий ард түмэн үүрсэн.

Тийм ч учраас тэр цаг үеэс хойш энэ тусгай албадын үйл ажиллагаа хуулийн хүрээнд тэр дотроо ард түмний дээд хяналтын хүрээнд байх ёстой шүү гэдэг үзэл санаа яригдаж хамгийн анх

Германы парламентад ийм бүтэц байгуулагдсан түүхтэй юм байна лээ.

Энэ Дэд хороо хэлбэрээр цаашидаа ажиллах асуудал бол хууль, эрх зүйн хүрээнд боловсронгуй болгох шаардлагатай гэж үздэг. Тэр ч хүрээнд өнгөрсөн онд ХЗБХ-ны даргаар ажиллаж байх үед бусад улс орны парламентад энэнтэй ойролцоо чиг үүргүүдийг хэрхэн ямар хууль эрх зүйн орчноор хэрэгжүүлдэг вэ гэдгийг ажлын хэсэг гаргаж холбогдох хууль тогтоомжийн төслийг бэлдсэн байдаг. Холбогдох судалгаануудыг хийсэн байдаг.

Яагаад гэхээр энэнтэй холбоотой парламентын тусгай чиг хяналтыг хийхтэй холбоотой төв судалгааны институт нь Швейцар улсад байдаг. Энд бүр ХЗБХ-ноос ажлын хэсэг гаргаж холбогдох судалгаа хуулийн төслийг хийж бэлдэж дууссан байдаг. Энэ хүрээнд бол манайх жишээлбэл энд байнгын, энд ажиллаж байгаа хүмүүсийн халдашгүй эрхийн асуудлууд нууцлалын асуудлууд албан ажлын албаны хүмүүсийн дархлаа, нийгмийн баталгаагаас эхлээд тусгай статустай байдаг юм байна лээ. Тэгэхээр энэ чиглэл боловсронгуй болгох шаардлага байгаа. Жишээлбэл Дэд хороо гэхэд ажлын алба байдаггүй. Иргэн хүн миний эрх зөрчигдлөө гэхэд түүнийг хянах ийм боломж хязгаарлагдмал байдаг. Тийм учраас энийг өргөтгөх шаардлагатай гэж үзэж байгаа.

**Г.Тэмүүлэн:** Гишүүд асуулт асууж дууслаа.

Нэр дэвшилт дээр тодорхой санал гараагүй байгаа. Ингээд нэр дэвшүүлж дууссан.

Дэд хорооны даргад нэр дэвшигчтэй холбогдуулж үг хэлэх гишүүн байна уу? Нэрсийг авъя. Тэмүүжин гишүүнээр тасалъя.

Тэмүүжин гишүүний микрофоныг өгье.

**Г.Тэмүүлэн:** Үнэхээр өнгөрсөн 30 жил Тусгай хяналтын дэд хороо ажлаа ямар хариуцлагатай ямар чиг үүрэгтэйгээр хэрэгжүүлсэн бэ гэдгийг үр дүн өөрөө нийгэмд байгаа. Нийгмээрээ айдастай ямар нэгэн гүйцэтгэх ажилд өртсөн, тагнаж чагнуулсан гэдэг эмээлтэй, хардалттай, бүгд ямар нэгэн байдлаар томоохон эрх мэдлийг гартаа бүрэн атгаж байгаа албан тушаалтнуудыг ярихдаа нэрээр нь дуудаж ярихаа байчихсан. Ихэнхдээ хочоор нь эс үгүй бол зангаж эсвэл хуруугаараа дугаар гаргаж ярьдаг болоод хувирчихсан. Бизнес эрхлэгчид болон нийгэмд нөлөө бүхий хүмүүс байнга миний утсан дээр ямар нэгэн чагнах тагнах хэрэгсэл байршсан, программ суусан. Миний утасны дуудлага болон мессежүүдийг хянаж байгаа гэдэг айдас хүйдэстэй. Ихэнх тохиолдолд утсаар ярихаасаа илүүтэйгээр ямар нэгэн социал платформоор мэдээллээ солилцох гэж оролддог. Гэнэн тийм бодолтой. Ний нуугүй хэлэхэд ер нь ингээд дагалдан тавих болон иргэний хувийн мэдээллийг цуглуулах зөвшөөрөлгүйгээр, хуульгүйгээр, шүүхийн хяналтгүйгээр цуглуулах үйл явц хавтгайрчихсан.

Хувь хүмүүсийн эмзэг мэдээлэл юм уу, эс үгүй бол хувийн мэдээллүүд нь төрийн байгууллага эрх бүхий байгууллагууд гэхээсээ илүүтэйгээр өндөр албан тушаалтнуудын цехэд хадгалагдсан байдалтай, хэрэгцээ гарсан үедээ айлгадаг, сүрдүүлдэг, ямар нэгэн аргаар шантаажилж дарамталдаг сүүлдээ энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд нь өөрсдөө албан тушаалтнаа өөрсдөө эрх мэдэлтнүүдийг хаана байрших улс төрчдийг хаана байхыг шийдэх хэмжээнд хүртэл галзуурчихсан. Ер нь бол нэ чиглэлийн байгууллагуудаар дамжуулаад бизнесийг нь дээрэмддэг, албан тушаалаас нь буулгадаг хэн нэгнийг хувийн амьдралынх нь хэмжээнд ямар байхыг хүртэл шийдэх хэмжээнд зах хязгааргүй болчихсон ийм 30 жилийг бүтээчихсэн байгаа бид. Үнэнийг хэлэхэд

нөгөө хуучин социализмын үеийн ногоон малгайт буюу эс үгүй бол Германы нөгөө нууц цагдаа гэдэг шиг хуультай хуульгүй үйл явц бол Монголын энэ ардчиллын үйл явц дотор ингээд гараад ирчихсэн. Энэний үр дагавар дээр бол хуулийн засаглал ноль. Хүний эрхийн баталгаа бол ноль, шантааж буюу айлган сүрдүүлэлтээр хүсэл зоригоо хэрэгжүүлдэг албан тушаалтнуудын эрх хэмжээ бол хэмжээ хязгааргүй болоод явчихсан. Энийг зогсоох хэд хэдэн арга зам байгаа. Уг нь энэ бол парламентын хяналт. Яах аргагүй ард түмний нэрийн өмнөөс парламентын хяналтаар хуулийн засаглалыг тогтоох, хүний эрхийг хамгаалах, эрүүл саруул дэг журамд оруулах хуулийн зохицуулалтад хүртэлх шаардлагууд байгаа. Нөгөө улс орнууд чинь хууль бусаар авсан энэ хувийн мэдээллээ албандаа ашигласан бол өндөр хариуцлага хүлээж байгаа. Ийм мэдээлэл цуглуулсан бол өндөр хариуцлага хүлээж байгаа. Хувьдаа ашигласан бол бүр өндөр хариуцлага хүлээж байгаа байхгүй юу.

Гэтэл манайхан бол хувьдаа ил цагаан ашигладаг болоод хувирчихсан. Тусгай албад нь бүр хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй болоод хэвлэл мэдээлэл сошиалын орчинд хүртэл зүгээр хүн харлуулах гүтгэх ямар нэгэн байдлаар хүнийг гэмт хэрэгтэн муу муухай хүн гэж хийхдээ хүртэл энэ аргыг хэрэглэдэг болоод хувирчихсан. Тэгээд энийг бол таслан зогсоохын тулд дахиад юу хэрэгтэй вэ гэхээр хуулийн орчин сайжруулахаасаа гадна зохион байгуулалтын чиг үүргийн хувьд үнэхээр аюулгүй байдлын Тусгай хяналтын дэд хороог 2 хуваахаас өөр арга байхгүй. Аюулгүй байдал буюу гадаад бодлогын байнгын хороон дээр байгаа энэ Тусгай хяналтын хороо үндэсний аюулгүй байдлыг хангахад зориулагдсан тусгай хороо. Хүний эрхийг хамгаалахад биш, хууль сахиулахад дээдлэхэд биш. ХЗБХ-н дээр энэ чиг үүргүүд байх ёстой. Иргэний үндсэн эрх, эрх чөлөөтэй хэсэг хууль дээдлэх энэ хэсэг бол ХЗБХ-ны үндсэн чиг үүрэг.



Нөгөө улс орнууд чинь бүр ХЗДХЯ-нд байгаа АГС болгон руу чиглэж байгаад Тусгай хяналтын.

**Г.Тэмүүлэн:** Тэмүүжин гишүүнд 1 минут нэмж өгье.

**Х.Тэмүүжин:** Тэгэхээр бид нар нөгөө парламентын хяналтаа үр дүнтэй болгохын тулд чиг үүргээ оновчтой зохион байгуулах бол хэрэгтэй байна. Эрх мэдлийн бөөгнөрлийг жоохон тодорхой хэмжээнд задлах хэрэгтэй байна. Мэдээж хэрэг тагнуул, арми гэдэг улс орны үндэсний аюулгүй байдалтай холбоотой учраас тэд бол хуульд зааснаас гадна хуульд заагаагүй олон арга хэрэгслээр үндэсний аюулгүй байдлыг хангах хэрэгтэй. Хууль сахиулах буюу гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагууд бол хуулиас гадуур ямар ч арга хэмжээ явуулж болохгүй. Гол зарчим нь. Иргэн нь тэр үйлдлийг хийхээр гэмт хэрэг болчихдог. Төр нь тэр үйлдлийг хийхээр хууль бусаар баривчилсан байна, цагдан хорьсон байна, жоохон эрх хэмжээгээ хэтрүүлсэн байна гэдэг зөөллөдөг аргалдаг арга хэрэгсэл рүү орж болохгүй. Хууль бусаар цагдан хорьсон юм уу баривчилсан байх юм бол энэ иргэн үйлдэхэд энэ хүн хулгайлах гэж байгаа, хүн алга болгох гэж байгаа, хүн барьцаалах гэж байгаа юм. Төр нь ирэхээрээ энэ ингэсэн байна гэж хууль бусаар хэн нэгний хувийн мэдээллийг тагнаж чагнасан байх юм бол иргэний хувьд бол ер энэ шууд гэмт хэрэг.

**Г.Тэмүүлэн:** Тэмүүжин гишүүнд баярлалаа. Их зөв зүйтэй санал санаачилгыг дэвшүүлж байна.

Дэд хорооны чиг үүрэг болоод хүний эрхтэй холбоотой асуудлуудаар. Ингээд гишүүд үг хэлж дууслаа.

Санал хураалтыг явуулж эхэлье. Тусгай хяналтын дэд хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Баттөмөр овогтой, Энхбаярыг сонгох саналыг

дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд бэлтгэлтэй байгаарай.

Санал хураалт.

Нийт хуралдаанд оролцсон гишүүдийн 100 хувийн саналаар дэмжигдсэн байна аа. Энхбаяр гишүүнд баяр хүргэж, амжилт хүсье.

Тэгээд парламентын хяналтыг бүрдүүлэх чиглэлээр санаачилгатай, хариуцлагатай ажиллахыг хүсье ээ танд.

Ингээд Баттөмөрийн Энхбаяр гишүүн парламентын гишүүдийн олонхын саналаар ингээд сонгогдлоо. Ингээд Тусгай хяналтын дэд хорооны дарга сонгосноор Байнгын хорооны тогтоол бол батлагдсанд тооцогдохоор байгаа. Та бүхэнд тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Дэд хорооны даргыг сонгох тухай Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.10, 27.11 дэх хэсэг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсгийг үндэслэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос тогтоох нь:

Монгол Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр Тусгай хяналтын дэд хорооны даргаар сонгосугай. Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн ийм тогтоол байна аа.

Ингээд Дэд хорооны дарга сонгосноор Байнгын хорооны тогтоол батлагдсанд тооцогдохоор байгаад байгаа.

Дэд хорооны даргыг сонгох асуудлыг хэлэлцэж дууслаа.

Ингээд өнөөдөр хэлэлцэх асуудал дууссан байна.

Байнгын хорооны хуралдаан өндөрлөснийг мэдэгдье ээ.

Гишүүдэд жич зарын шинж чанартай зүйл гэхэд манай Байнгын хорооны үйл ажиллагаанд хамаарах БХЯ болоод Гадаад хэргийн яаманд бид бүхэн газар дээр нь очиж танилцахаар байгаад байгаа. Нэг дэх өдрийн 2 цагаас БХЯ дээр болон Жанжин штаб дээр байгаад байгаа. Ирэх 3 дахь өдрийн үдээс хойш Гадаад хэргийн яаман дээр байгаад

байгаа. Гишүүд маань идэвхтэй оролцоорой гэж та бүхэнд хүсэх байна. Баярлалаа.

09.56 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС УРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА